

## **АГУУЛГА**

1.	ҮЙЛДВЭРИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	2
2.	ҮЙЛДВЭРИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ .....	4
3.	ҮЙЛДВЭРИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	5
4.	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ .....	7
5.	СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	8
6.	ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	11
7.	ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	12
8.	ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	13
9.	ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	14
10.	ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР .....	16
11.	ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	18
12.	ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧИДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	19

## **1. ҮЙЛДВЭРИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК нь 1990 оны Сайд нарын зөвлөлийн 160 дугаар тогтоолоор Монгол, Япон хоёр орны Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны гэрээний дагуу Дархан Сэлэнгийн бус нутгийн төмрийн хүдрийн орд газруудыг түшиглэн Дархан-Уул аймагт байгуулагдсан түүхтэй. 1994 онд үйлдвэр ашиглалтанд орсноос хойш компанийн үйл ажиллагаа өргөжин тэлсээр Уул уурхайн олборлолт, боловсруулалт, Төмөрлөгийн үйлдвэрлэл, Гадаад болон дотоод худалдаа гэсэн үндсэн чиглэлүүдээр үйл ажиллагаа явуулж байна. “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК нь Монгол улсдаа хар төмөрлөгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хамгийн том компани юм.

Монгол улсын Засгийн газрын 1990 оны 160-р тогтоолыг үндэслэн Монгол Япон улсуудын Засгийн газар хоорондын байгуулсан гэрээ ёсоор 100 мянган тонн цувимал үйлдвэрлэх хүчин чадалтай анх байгуулагдаж 1993 оны 10 дугаар сарын 23-нд хайлах цех, 1994 оны 07 дугаар сарын 04-нд үйлдвэрийг бүрэн хэмжээгээр ашиглалтанд оруулсан. 115\*115 мм хэмжээтэй болд, SD295A, SD345, SD390, SD490, CT70 ангилалын 10-80мм голчтой дугуй туйван, SS440 ангилалын 30\*30\*3, 45\*45\*5 мм-ийн булан төмөр үйлдвэрлэж эдгээр бүтээгдэхүүнүүд нь стандартын шаардлагыг бүрэн хангаж байгаа тул 2001 онд тохиролын тэмдэг авсан.

“Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК нь 1500 гаруй ажилтан албан хаагчидтай, үйлдвэрийн ажилчидын 75 орчим хувь нь 31-40 насны залуучууд байна.

Удирдлага зохион байгуулалтын хувьд үндсэн цехүүдээс гадна Үйлдвэр технологийн газар, Стратеги бизнес хөгжлийн газар, Санхүүгийн удирдлагын газар, Байгаль орчин ХАБЭАХ, Ган үйлдвэрлэл технологийн хэлтэс, Дотоод хяналтын хэлтэс, Уул уурхайн үйлдвэрлэл технологийн хэлтэс, Худалдан авах ажиллагааны хэлтэс, Хуулийн хэлтэс, Тээвэр ложисикийн хэлтэс, Хүний нөөц сургалт сурталчилгааны хэлтэс, Борлуулалт, маркетингийн хэлтэс, Хөгжлийн хэлтэс, Санхүү эдийн засгийн хэлтэс, Чанар хяналтын хэлтэс, Аж ахуйн алба, Харуул хамгаалалт аюулгүй байдлын алба Техникийн хяналтын албатайгаар, үйлдвэрийг удирдлагаар хангаж ажиллаж байна.

**Байришил:** Дархан-Уул аймаг, Хонгор сумын 1-р багийн нутагт газрын гэрчилгээ 000012082 дугаартай эзэмшлийн 4.5га, 000012078 дугаартай эзэмшлийн 14га, 000012088 дугаартай эзэмшлийн 17га, 000012087 дугаартай эзэмшлийн 1.5 га, энэхүү үйлдвэрийн зориулалттай газрууд нь 1:100000 масштабтай байр зүйн зургийн М-48-92 тоот хавтгайд орших бөгөөд нийт 32.5 га талбайг хамарна.

**Цахилгаан хангамж:** Цахилгаан эрчим хүчний 100 квт-ын хуваарилах дэд станц Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээний 110/22/16.6/6 кв-ын Дархан 220 дэд өртөөнөөс 2 хэлхээ агаарын шугамаар холбогдсон.

**Усан хангамж:** Дархан хотын төвлөрсөн ус хангамжаас хангагддаг, усны 60-70 орчим хувийг эргэлтийн системээр хэрэглэнэ. Харин 30%-ийг нэмэлт эх үүсвэрээс авч хэрэглэх бөгөөд Дарханы Ус Суваг ХК-тай жил тутам гэрээ хийдэг.

**Дулаан хангамж:** Төвийн дулааны шугамтай холбогдсон.

## **2. ҮЙЛДВЭРИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ**

Дархан-Уул аймгийн Хонгор сумын 1-р багийн нутагт 1:100000 маштабтай байр зүйн зургийн М-48-92 тоот хавтгайд орших бөгөөд нийт 32.5 га талбайг хамарна.

Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэр нь Монгол орны хойд хэсэгт Хангай Хэнтийн уулархаг нутгийн завсар Орхон, Сэлэнгэ болон Хараа голын сав газар бэсрэг болон нам уулууд тэдгээрийн хоорондох өргөн нарийн уудам хөндий бүхий далайн түвшнээс дээш 700-1500м өндөрт өргөгдсөн харьцангуй нам дор газар байрладаг. Дархан-Уул аймаг нь 4 sumaас бүрддэг.

Дархан-Уул аймаг нь газарзүйн байрлалын хувьд хойд өргөргийн  $49^{\circ}50'$ - $49^{\circ}54'$ , зүүн уртрагийн  $105^{\circ}50'$ - $106^{\circ}49'$ -ийн хооронд нийтдээ 330 мянган га нутаг дэвсгэртэй бөгөөд гуу жалгаар хэрчигдсэн, тэгш биш долгиолог гадаргуутай байдаг.

Монгол орны ботаник газарзүйн мужлалаар Монгол-Дагуурын уулын ойт хээрийн тойрот хамарагдана.

Тойргийн захын битүү хотгоруудад бударгана, хэрс, дэрстэй цөлөрхөг хээрийн элементүүд ч ажиглагдана. Энэ тойрог нь манай орны бүх дэвсгэр нутгийн 6.62%-ийг эзлэнэ. Одоогоор энд 446 зүйл гуурст ургамал бүртгэгдсэний дотор 115 зүйл модлог, сөөглөг ургамад (тойргийн ургамлын 87.75%) байна.

Төслийн 5 км нөлөөллийн бүс дотор 13 зүйлийн хөхтөн, 15 зүйлийн шувуу (Бүс нутгийн улаан данс), хээрийн ажиглалт судалгаагаар 16 зүйл, 5 зүйлийн хоёр нутагтан, мөлхөгчид амьтан тохиолдох боломжтой. Хөхтөн амьтдын урт сүүлт зурам, бор туулай зэрэг мэрэгч амьтад тоо толгой элбэг тааралддаг бол нутгийн иргэдийн аман мэдээгээр саарал чоно, үнэг зэрэг махчин амьтад цөөн тохиолддог байна. Харин шувуудын зүйлийн баялаг нэлээд өндөр 10.7% суурин, 41.5% нь нүүдлийн үедээ дайрч өнгөрдөг, 7.6% нь өвөлждөг, 7.6% нь зусдаг бол 32.3% нь зусаж, үрждэг байна.

2023 оны 6 дүгээр сараас эхлэн “Эрдэнэс Монгол” ХХК-ийн охин компани болон үйл ажиллагаагаа явуулж байна.

Бид Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг өргөтгөн шинэчлэх, хүчин чадлыг нь нэмэгдүүлэх, Дархан-Сэлэнгийн бүс нутагт “Ган үйлдвэрлэлийн цогцолбор” үйлдвэр байгуулах ажлын хүрээнд төслийн техник эдийн засгийн үндэслэлийг бэлэн болгож, бүтээн байгуулалтын бэлтгэл ажлууд руу ороод байна.

Дээрх төсөл хэрэгжсэнээр Монгол Улсад төмрийн хүдрээс эцсийн шатны ган бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой болох, дотоодын ган бүтээгдэхүүний хэрэгцээг хангах, орон нутагт 2000 орчим ажлын байр шинээр бий болгох, аймгийн төсөвт төвлөрүүлэх татварын хэмжээг өсгөх, жижиг дунд үйлдвэр кластерын хэлбэрээр хөгжих таатай нөхцлийг бүрдүүлэх, Монгол Улсын нийгэм эдийн засгийн хөгжилд жинтэй хувь нэмрийг оруулах зэрэг ихээхэн ач холбогдолтой.

### **3. ҮЙЛДВЭРИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ**

**Агаарын чанар:** Төслийн явцад агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл нь автомашины утаа, санамсар болгоомжгүйгээс үүссэн химиин бодисын алдагдал үүнээс үүсэх хийн хаягдал, тоосжилт байх боломжтой юм. Тоосжилтын эх үүсвэрүүд нь:

- Авто тээвэрийн хэрэгсэлийн засвар үйлчилгээ, тохижилтын ажлын үед
- Түүхий эд, эцсийн бүтээгдэхүүн ачиж буулгах, бэлдэх талбай дээрх машин механизмын хөдөлгөөн, дуу чимээ
- ШТС агуулах, ШТМ алдагдах агаарын чанар
- Химиин бодис тээвэрлэж буй машинаас асгарч болох шороо тоос

**Хөрсөн бүрхэвч:** Хөрс элэгдэж эвдрэх, бохирдох нөлөөлөл агуулахыг барьж байгуулах үед болон салаа зам гарах, хөрс хуулах, түрэх, овоолго хийх, хучилт хийх, суваг шуудуу далан, барилга байгууламжийн ажлын үед хөрс, гадаргын урсацад өөрчлөлт орж хөрсний эвдрэл үүсэх бөгөөд үүнд бас гадаргын хэвгий, хөрсний шинж чанар, гадаргын урсац, ургамалжилт зэрэг хүчин зүйлүүд нөлөөлнө.

**Амьтны аймаг:** Барилга байгууламжийг завар үйлчилгээний үед машин, техникийн нөлөөгөөр үүсэх дуу чимээний нөлөөллөөс шалтгаалан тухайн орчны амьтад үргэн дайжиж, амьтадын орон зайн өөрчлөлт бий болох, дараа нь үйл ажиллагааны явцад хатуу хог хаягдал болон шингэн хаягдлыг зөв байршуулаагүй дүүрсэн тохиолдолд зайлуулахгүй удаах зэргээс болж орчны хөрс бохирдож улмаар хөрсний бичил организмууд хордох зэрэг сөрөг нөлөөллүүд үүсч болзошгүй.

**Ургамлан нөмрөг:** Ургамлын нөмрөгт үзүүлэх шууд сөрөг нөлөөллийн хүчин зүйлүүд нь шороон зам, машин, хүний үйл ажиллагаанаас уг талбайнуудын ургамлын нөмрөг маш бага байна. Бүрмөсөн устах ургамлаас гаднах талбайн ургамлууд тоосжилт ба талхагдлаас шалтгаалж ургац бүтээмж доройтож, шарилж, лууль зэрэл ургамал нэмэгдэх сөрөг нөлөөтэй.

**Усан орчин:** Үйлдвэрийн түүхий эд, эцсийн бүтээгдэхүүн, химиин бодис тээвэрлэхэд ашиглаж буй тээврийн хэрэгслээс алдагдах шатахуун, агуулахын үйл ажиллагаанаас ил задгай хог хаягдал гадаргын урсацаар зөөгдөн тархах болзошгүй гэвч энэ тохиолдолд үүсэхгүй байх магадлалтай

**Хог хаягдал:** Хату, шингэн хог хаягдлаа ил задгай хаяж хөрс, ургамал, агаар орчинг бохирдуулж болзошгүй.

**Хүний эрүүл мэнд:** Хордуулах зэрэглэлээс хамааран мэргэжлийн өвчин үүсгэж болзошгүй.

- Амьсгалын систем
- Төв мэдрэлийн систем
- Элэг
- Бөөр
- Зүрх
- Нүд
- Хорт хавдар
- Цусны цагаан бөөм өвчин үүснэ.

#### **4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ**

Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь Дархан төмөрлөгийн үйлдвэрийн технологиос байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг арилгах, бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ Байгаль орчныг хамгаалах тухай хууль, БОНБНҮ, байгаль орчны аудит, газрын төлөв байдал чанарын хянан баталгаа, төрийн болон хяналтын байгууллагуудын зөвлөмж үнэлгээг удирдлага болгон хүн, байгаль төвтэй үйлдвэрлэлийн бодлогыг хэрэгжүүлэн ажиллахад оршино. Бид дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

- Компанийн байгаль орчны бодлогыг хэрэгжүүлэх,
- Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- DMP цогцолборт төгөл бий болгох ажлыг үргэлжлүүлэх
- Байгаль орчны удирдлагын тогтолцоо ISO14001:2015 стандартыг үйлдвэрлэлийн үйл ажиллагаандaa нэвтрүүлэх

## 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллийд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Үйлдвэрийн талбайн орчмын авто машины хөдөлгөөн ихэссэнээс агаар дахь тоосны хэмжээ, CO, SO <sub>2</sub> , NO <sub>2</sub> ихсэж, орчны хүчилтөрөгчийн (O <sub>2</sub> ) хэмжээ багасах	Агаарын чанарт хяналт тавих, агаар бохирдуулагч бодисын хяналтыг тодорхой төлөвлөгөөний дагуу тогтмол хийх	Үйлдвэрийн орчин	-	-	ОХШХ-т тусгасан	Улирал тутам	Агаарын тухай хууль, MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага	
2		Тээврийн хэрэгслийн сул ажиллагааг хязгаарлах, хяналт тавих, анхааруулах тэмдэг байршуулах	Үйлдвэрийн бүх машин механизм, тээврийн хэрэгсэл	-	-	Дотоод зардал	Тогтмол	Агаарын тухай хууль, MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага	
3		Машин механизмуудын яндан шүүлтүүр тавих	Үйлдвэрийн машин механизм, тээврийн хэрэгсэл	ш	3	60,000	180,000	1-р улиралд	
4	Ил задгай хог шатааснаас агаарт хорт хий ялгарах	Тогтмол хяналт тавьж ил задгай хог шатаалгахгүй байх	Үйлдэрийн орчин	-	-	Дотоод зардал	Тогтмол	Хог хаягдлын тухай хууль	
5	Хог хаягдаас үүдэлтэй таагүй үнэр, өвчин үүсгэгч агаар орчинд тархах	Хог хаягдлыг тогтмол хугацаанд зайлцуулж, ариутгал хийх	Үйлдвэр, Зулзагын амралтын хогийн цэгийн орчин	-	-	Дотоод зардал	Жилд 2 удаа	Хог хаягдлын тухай хууль	
6	Нутгийн иргэдийн амгалан тайван байдлыг алдагдуулах	Дуу шуугианы хэмжилт хийж, дуу шуугиан бүхий	Үйлдвэрийн орчин	цэг	5	Дотоод зардал	Улирал тутам	MNS ISO 226:2003 Дуу чимээ-хэвийн	

		машин механизмын ашиглалтыг оновчтой төлөвлөх, үр ашиггүй ашиглалтыг багасгах						норм-түвшний хэмжээ
7	Тог цахилгаан ихээр зарцуулах	Сэргээгдэх эрчим хүчээр ажилладаг гэрэлтүүлэг тавих	Үйлдвэрийн орчин	ш	4	1,400,000		
8	Усны бохирдол, шатах тослох материалыг алдсанаар газрын доорх ус бохирдох, газар доорх устай холбогдон ургадаг ургамалжилтад сэргэөр нөлөөлж болзошгүй	Бохир ус дамжуулах хоолойн холбоосуудаар ус алдагдаж байгаа эсэхийг үе үе хянах, тухай бүр нэн даруй засвар хийх	Бохир усны шугам дагуу	-	-	Дотоод зардал	Тогтмол	Усны тухай хууль, Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010, Усны чанар, хаягдал ус MNS 4943:2015
9		Үйлдвэрийн орчны хариуцсан талбайг үерийн усны урсацаас хамгаалах зорилгоор далан байгуулах, эвдэрсэн тохиолдолд засварлах	Үйлдвэрийн орчин	Удаа	1	100,000	1 удаа	
10		Шатах тослох материал алдагдах үед авах яаралтай арга хэмжээг урьдчилан тодорхойлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах	ШТС-н орчим, Засварын төвийн орчим	цэг	2	Дотоод зардал	Тогтмол	
11	Замгүй газраар шинэ зам үүсгэн хөрсний эвдрэл үүсэх, тоос шороо ихсэх	Явган зам, зам талбайг шинээр хийх	Үйлдвэрийн орчин	-	-	Хаягдал тоосго ашиглан дотоод зардлаар	Жилд 1 удаа	Хог хаягдлын тухай хууль,
12	Шатах тослох материал, хог хаягдлаас хөрсөнд бохирдол үүсэх	Шатах тослох материал алдагдах, гэнэтийн ослын үед	Үйлдвэрийн орчин	-	-	Дотоод зардал	Тогтмол	Хөрс хамгаалах, цөлжилтөөс

		ашиглах асгаралтын иж бүрдэл, багаж, материал төхөөрөмж бэлэн байлгах						хамгаалах тухай хууль
13	Ахуйн хатуу хог хаягдлаар хөрс бохирдох	Хог хаягдлыг ангилан ялгаж байх		-	-	ХХМ-н хэсэгт тусгасан	Тогтмол	Хог хаягдлын тухай хууль
14		Хөрсний хяналт шинжилгээг тогтмол хуваарийн дагуу хийх	Хогийн цэгийн орчим	-	-	ОХШХ-т тусгасан	Жилд 2 удаа	MNS 5850:2019
15	Нефтийн бүтээгдэхүүнээр хөрс бохирдох	Нефтийн бүтээгдэхүүнээр хөрс бохирлогдсон газарт хөрсийг саармагжуулах арга хэмжээ авах	Үйлдвэрийн орчин	-	-	Дотоод зардал	Тухай бүр	Хөрс хамгаалах, цөлжилтөөс хамгаалах тухай хуулы
16	Ургамлан нөмрөг хүн, техникийн нөлөөгөөр устах, сийрэгжих, улмаар ургамлан нөмрөг их хэмжээгээр алдralд орох эх үүсвэр болох	Үйл ажиллагаа явагдахаас өөр газруудад машин, техник явуулахгүй байх, замын нэгдсэн сүлжээг гаргах	Үйлдвэрийн орчин	-	-	Дотоод зардал	Тогтмол	MNS 5918:2008
	<b>Нийт</b>					<b>1,680,000</b>		

## 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа бадавтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Цэцэгжүүлэлт орчны нөхцөл сайжруулах ажилтнуудын тав тухтай байдлыг нэмэгдүүлэх	Цэцгийн мандал хийх	Үйлвэрийн орчин	ш	500	4000	2 000 000	Дулааны улиралд	Шөнө нэмэх градустай байх үед тарих
	Шинээр талбайг зүлэгжүүлэх	Үйлвэрийн орчин	m <sup>2</sup>	1000	1000	1 000 000	6 сард	-
Тарьж ургуулсан мод, бутыг тайрч танаж хэлбэржүүлэх	Модыг тайрах насжилтыг уртасгах, ургалтыг дэмжих өнгө үзэмжийг сайжруулах	Үйлдвэрийн бүх хэсэгт	га	1	-	Дотоод зардал	Тухай бүр	Модыг тайрч танаж хэлбэржүүлэх энгийн аргаар
Орчны агаарын чанарыг сайжруулах	Зүлэгжүүлсэн талбайг услах	Зүлэгжүүлсэн талбай бүрийг хуваарийн дагуу	m <sup>2</sup>	4000	Дотоод зардал	Дотод зардал	Дулааны улиралд	-
“Тэрбум мод” хөдөлгөөний хүрээнд мод тарих	Компанийн “Нэг сая” төлөвлөгөөний дагуу мод тарих	Үйлдвэрийн орчин	ш	500	5,000	2 500 000	Хавар, намар	-
	<b>Нийт</b>					<b>5,500,000</b>		

## **7. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төслийн талбай болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл ба археологийн олдвортой газар байхгүй. Төслийн хэрэгжилтийн явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олдох үед холбогдох хууль тогтоомжид заасны дагуу засаг захиргааны байгууллага болон холбогдох байгууллага болох ШУА-ын Түүхийн хүрээлэнд даруй мэдэгдэж төслийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоно.

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	1	2	3	4	5	6	7	8
	Үгүй	-	--	-	-	-	-	-

## 8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ажлын нөхцөл ажилчлын эрүүл мэндэд нөлөөлөх	Ажиллагсадыг жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах.		-	Дотоод зардал	Байнга	ХАБЭА-н тухай хууль
2		Ажиллагсадыг хувийн хамгаалах хэрэгслээр хангах, хоргүйжүүлэх нэмэлт бүтээгдэхүүнээр тогтмол хангах		-	Дотоод зардал	Байнга	Гамшгаас хамгаалах тухай хууль
3	Үйлдвэрийн хэсэгт гол алдах	Гал унтраах хэрэгслээр үйлдвэрийг бүрэн хангах арга хэмжээ авах, гал унтраах талаар тодорхой түвшинд бэлтгэлийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах	Үйлдвэрийн бүсэд	-	Дотоод зардал	Байнга	Гамшгаас хамгаалах тухай хууль
4	Үер, гал түймэр, газар хөдлөлт, хүн малын гоц халдварт өвчин	Байгалийн гамшиг, гэнэтийн ослоос сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, батлуулах	Үйлдвэрийн бүсэд	-	Дотоод зардал	Байнга	Галын аюулгүй байдлын тухай хууль
<b>Нийт</b>					<b>Дотоод зардал</b>		

## 9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын ангилаал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүү лэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Ахуйн	НААҮГ-тай гэрээ байгуулан ачилтыг хугацаанд нь хийлгэх	Үйлдвэр, Ган Урсгал амралтын хогийн цэгүүдийн орчин	$m^3$	48	10,000	480 000	Улирал бүр	Хог хаягдлын тухай хууль
	Хог хаягдлыг ангилан ялгаж түр хадгалах, дахин боловсруулах боломжтой хогийг зөвшөөрөлтэй газар нийлүүлэх	Хуванцар савнууд	удаа	4	-	Дотоод зардал	Жилд 4 удаа	Хог хаягдлын тухай хууль
	Нийтийн эзэмшилийн талбай, үйлчилгээний орчинд болон хариуцан хамгаалах талбайн орчинд хогийн сав байрлуулах	Үйлдвэрийн орчин	-	-	Дотоод зардал		Жилд 1 удаа	Хог хаягдлын тухай хууль
Үйлдвэрийн	Хог хаягдлыг дахин боловсруулах	Хаягдал шаарнаас металл хэсгийг ялган дахин үйлдвэрлэлийн процесст ашиглах	удаа	1	-	Дотоод зардал	Жилд 1 удаа	Хог хаягдлын тухай хууль
	Технологийн хаягдлуудыг холилдож, хөрс бохирдуулахаас сэргийлж тусад нь хадгалах	Технологийн хаягдлын цэг	-	-	-	Дотоод зардал	Тогтмол	Хог хаягдлын тухай хууль
Аюултай	Хаягдал төмөртэй хамт аюултай хог хаягдал орж ирэхгүй байхад тогтмол хяналт тавьж ажиллах	Үйлдвэрийн орчин	-	-	-	Дотоод зардал	тогтмол	Хог хаягдлын тухай хууль

	Эмнэлгийн хог хаягдлыг мэргэжлийн байгууллагад өгч устгуулах	Эмнэлгийн хог хаягдал	удаа	40	3,000	120,000	7 хоног бүр	Аюултай хог хаягдлыг устгах тухай журам
	Химийн аюултай хог хаягдлыг мэргэжлийн байгууллагад өгч устгуулах	Химийн бодисын ашигласан сав, баглаа боодол	удаа	2	-	300,000	Жилд 2 удаа	Аюултай хог хаягдлыг устгах тухай журам
	Ашигласан тос, маслыг мэргэжлийн байгууллагаар өгч устгуулах	Ашигласан тос, масло	Удаа	2	-	300,000	Жилд 2 удаа	Аюултай хог хаягдлыг устгах тухай журам
	Аюултай хог хаягдлын бүртгэл хөтлөж, хяналт тавих	Үйлдвэрийн орчин	удаа	12	-	Дотоод зардал	Сар бүр	Хог хаягдлын тухай хууль
<b>Нийт</b>						<b>1,200,000</b>		

## 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	<p><b>Агаарын чанар:</b> O<sub>2</sub>, SO<sub>2</sub>, CO, NH<sub>3</sub> нийт тоос, PM2.5, PM10, Дэгдэмхий бодисуудыг тодорхойлох, Үйлдвэр орчмын дуу чимээ</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Уутан филтерийн орчим</li> <li>• Дизель агуулах</li> <li>• Төмөр бэлтгэх цех</li> <li>• Азотын хий ялгарч байгаа хэсэг</li> <li>• Химийн бодис хадгалах тусгай өрөө</li> </ul>	Улирал тутам	4	50,000	200,000	-	MNS 4585:2007 MNS 3384:1982 MNS 4048:1988 MNS 0017-2-5-11:1988 MNS 5013:2009 MNS 5014:2009 MNS 5885:2008
2	<p><b>Усны хяналт шинжилгээ:</b> pH, ууссан давс, хатуулаг, Ca, Mg, Na, K, SO<sub>4</sub>, NO<sub>2</sub>, NO<sub>3</sub>, NH<sub>4</sub>, As, Cd, Cu, Hg, Pb, Zn, Cr, Fe, Ni, үнэр, өнгө, нүүрсустөрөгчид</p> <ul style="list-style-type: none"> <li>• Нянгийн шинжилгээ</li> <li>• Нийт болон чөлөөт цианид</li> <li>• Бохир усны шинжилгээ</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Цайны газрын ахуйн хэрэглээний ус</li> <li>• Хаягдал ус нийлүүлэх хэсэг</li> </ul>	Жилд 2 удаа	2	160,000	320,000	-	MNS ISO 4867:1999, MNS 4586:19988 MNS ISO 5667-14:2000, MNS 13.060.50, MNS 0900:2010
3	<p><b>Хөрсний төлөв байдал, бохирдол:</b> Хөрсний морфологи бичиглэл, pH, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж,</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Технологийн хаягдлын талбай</li> <li>• Засварын төв</li> </ul>	5, 9 сард	2	80,000	160,000	-	MNS 3307:19918 MNS 3308:19918 MNS 3309:1991, MNS 3675:19848 MNS 4006:19878

	шим тэжээлийн элемент /NO <sub>3</sub> , P <sub>2</sub> O <sub>5</sub> , K <sub>2</sub> O/, хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устэрөгчийн нэгдлүүд, Хүнд металлын шинжилгээ K, Ca, Ti, Cr, Mn, Fe, Co, Cu, Zn, As, Se, Sr, Pb, Hg, S, Cl тодорхойлох, нийт болон чөлөөт цианид	<ul style="list-style-type: none"> <li>• Түүхий эд хүлээн авах цэг</li> <li>• Түүхий эд жижиглэх цэг</li> <li>• Түүхий эдийн хуримтлалын цэг</li> <li>• Төв замаас үйлдвэрийн хашааны хаалга хүрэх замд цэг сонгох</li> </ul>						MNS 3298:1991, MNS ISO 11047:2001 MNS 3675:1984
4	<b>Хаягдал зэв, шаар шинжилгээ:</b> NNP, AP, NP/AP, pH, S-NXS, S-Pug, S-SO <sub>4</sub> , S-tot, S-HCl, NAG test	<ul style="list-style-type: none"> <li>• Хаягдлын сан</li> </ul>		2	200,000	400,000		MNS 3307:19918 MNS 3308:19918 MNS 3309:1991, MNS 3675:19848 MNS 4006:19878 MNS 3298:1991, MNS ISO 11047:2001 MNS 3675:1984
	<b>Нийт</b>					<b>1,080,000</b>		

**11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төлөвлөсөн арга хэмжээ	Үрьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
		2025 он		
		Сар		
Ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах	Дотоод зардал	1-12 сар	Байгаль орчны инженерүүд, ХАБ-н инженер	-
Байгаль орчныг хамгаалах талаар сургалт зохион байгуулах, холбогдох орон нутгийн байгаль орчны алба болон байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	Дотоод зардал	1-12 сар	Байгаль орчны инженерүүд	
Байгаль орчныг хамгаалах жилийн тайланг орон нутгийн засаг захиргаанд цаг тухайд нь гаргаж өгч байх	Дотоод зардал	11 сар	Байгаль орчны ахлах инженер, Байгаль орчны инженер	-
Байгаль орчны удирдлагын тогтолцоо ISO14001:2015 стандартыг үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа нэвтрүүлэх	Дотоод зардал	1-12 сар	Байгаль орчны ахлах инженер, Байгаль орчны инженер	
Байгаль орчны нийцлийн аудит хийлгэх	15,000,000	1-12 сар	Байгаль орчны ахлах инженер, Байгаль орчны инженер	
<b>Нийт</b>	<b>15,000,000</b>			

**12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БУСЭД ОРШИН СУУГЧИДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлagnах оролцогч талууд	Тайлagnах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлagnах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	Дархан-Уул аймгийн Засаг даргын тамгийн газар	Үйлдвэрийн байгаль хамгааллын ажлын талаар мэдээлэл өгөх		2025/11	Дотоод зардал	Байгаль орчны ахлах инженер, Байгаль орчны инженер	Дархан-Уул аймаг
2	Нөлөөлөлд өртөгч оршин суугчид	Үйлдвэрийн үйл ажиллагаанаас байгаль орчинд Үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар мэдээлэх	Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүний биелэлт, гүйцэтгэл	2025/04	500,000	Байгаль орчны ахлах инженер, Байгаль орчны инженер	Дархан-Уул аймаг, Хонгор сум
3	БОУАӨЯамны ХБОБНУ-ын газарт	Тайлан, төлөвлөгөө батлуулах		2025/11-2026/01	Дотоод зардал	Байгаль орчны ахлах инженер, Байгаль орчны инженер	Улаанбаатар хот
	<b>Нийт</b>				<b>500,000</b>		

**13. ГАНГИЙН ҮЙЛДВЭРИЙН 2025 ОНД БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХААР ТӨЛӨВЛӨСӨН НИЙТ ЗАРДАЛ**

<b>№</b>	<b>Арга хэмжээ</b>	<b>Зардал, төг</b>
1	Сөрөг нөлөөллийг бууруулах	1,680,000
2	Орчны тохижолт, цэцээрлэгжүүлэлт	5,500,000
3	Түүх соёлын өвийг хамгаалах	-
4	Осол эрсдэлийн менежмент	Дотоод зардал
5	Хог хаягдлын менежмент хэрэгжүүлэх	1,200,000
6	Орчны хяналт шинжилгээ	1,080,000
7	Удирдлаг зохион байгуулалт	15,000,000
8	БОМТ-г нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах	500,000
<b>Нийт</b>		<b>24,960,000</b>